

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**/Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын шинэчлэн найруулсан дүрэм/**

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай" Монгол Улсын хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Зарлиг болгох нь:

- 1.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын шинэчлэн найруулсан дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 132 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАНБАНДИ